

## Монголын Скаутын Холбооны 2009-2011 хүртэлх Стратеги төлөвлөгөө

<b>Стратегийн хандлага: Гишүүнчлэлийн хүрээг тэлэх</b>	
<b>2013 он гэхэд гишүүнчлэлийг 21.000-д хүргэж, нас болон хүйсийн харьцааг ижил түвшинд хадгалан, нийгмийн бүхий л шатанд хүрч ажиллана.</b>	
<b>Зорилт 1: 2011 оны 10 сар гэхэд нийт скаутуудын тоог 15000-д хүргэнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Скаутын гишүүний тоо 15000 болсон, түүний 40% нь каб, 40% нь скаут, 15% нь венчир, 5% нь ровер байх ба үндэсний хэмжээнд бүх бүлгэмүүдийг хамарсан байна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 1 сарын 10 гэхэд 21 Аймаг, сум, нийслэл, дүүргүүдийн хэмжээнд скаут насны нийт хүүхэд залуучуудын судалгааг гаргана	ҮТШ-ын дарга
2009 оны 2 сарын 1 ээс эхлэн одоо байгаа аймаг дүүргийн скаутын зөвлөлийн гишүүнчлэлийн байдалд дүн шинжилгээ хийнэ	ҮТШ-ын дарга
2009 оны 4 сарын 10 гэхэд гишүүнчлэлийн хүрээг тэлэх 3 жилийн төлөвлөгөөг аймаг, дүүргийн жилийн өсөлт, сургалтын хэрэгцээ, бүртгэл, үнэлгээ өгөх заавар зэргийг багтаан боловсруулна.	ҮТШ-ын дарга
2009 оны 4 сарын 16 гэхэд гишүүнчлэлийн хүрээг тэлэх төлөвлөгөөг Товчоогоор батлуулж АДСЗ-үүдэд хүргүүлнэ.	МСХ-ны Гүйцэтгэх захирал
АД-ийн хэмжээнд гишүүнчлэлийг өсгөх компаниг ажлыг 2009 оны 9 сар гэхэд зохион байгуулна.	ҮТШ-ын дарга, ОНХ товчооны гишүүн
2009 оны 12 сарын 20 гэхэд бүх түвшинд ажиллах насанд хүрэгчдийн сургалтыг гишүүнчлэл өгөх төлөвлөгөөнөөс үндэслэн зохион байгуулна.	ҮТШ-ын дарга
2010 оноос эхлэн гишүүнчлэлийн хүрээг тэлэх төлөвлөгөөнд улирал тутам үнэлэлт өгч, жилийн эцэст дараа жилийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.	ҮТШ-ын дарга
<b>Зорилт 2: 2009 оны 1 сар гэхэд гишүүдийн бүртгэлийн програмыг бүх түвшинд хэрэглэж эхэлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Бүртгэлийн тогтолцоо ажиллаж эхэлнэ. Гишүүдийн тоо бүх шатанд бодиттой гарна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2008 оны 10 сарын 15-наас эхлэн гишүүдийн бүртгэлийн програмыг ХУД, БЗД, Дархан-Уул, Хэнтий аймгуудад туршиж эхэлнэ.	ҮТШ-ын дарга
2008 оны 12 сарын 15 гэхэд туршигдсан бүртгэлийн програмд дүн шинжилгээ хийнэ.	ҮТШ-ын дарга
2009 оны 1 сарын 30 гэхэд аймаг дүүргийн зөвлөлд бүртгэлийн системийг ашиглах талаар сургалтыг зохион байгуулна.	ҮТШ-ын дарга
2009 оны 2 сарын 15-наас эхлэн бүх аймаг дүүрэгт хэрэгжүүлж эхэлнэ.	МСХ-ны Гүйцэтгэх захирал, АДСЗ-ийн дарга, ОНХ товчооны гишүүн
Жил бүрийн 12-р сард ГБСистемд дүн шинжилгээ хийнэ	ҮТШ-ын дарга

## Стратегийн хандлага: Залуучуудын оролцоо

*Скаутын хөтөлбөрийг хүүхэд, залуучуудын хэрэгцээ сонирхолд нийцсэн уян хатан, боловсронгуй болгон залуучуудыг шийдвэр гаргах, тэдний оролцоонд тулгуурлан өөрийгөө хөгжүүлэх, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулахад нь тусална.*

<b>Зорилт 1: 2009 оны 1 сар гэхэд Каб, скаутын дахин боловсруулагдсан хөтөлбөрийг ҮЗ-ийн хуралд танилцуулан батлуулна. 2010 оны 1 сар гэхэд Венчир, роверын хөтөлбөрийг дэлхийн хөтөлбөрийн бодлоготой уялдуулан шинээр боловсруулна.</b>	<b>Хүрэх үр дүн: Каб, скаутын хөтөлбөр үндэсний хэрэгжиж эхэлсэн, венчир, роверийн шинээр боловсруулж хөтөлбөрийг батлуулна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2008 оны 10 сарын 30 гэхэд ровер, венчерийн хөтөлбөрийг боловсруулах санал асуумжийг боловсруулна	Хөтөлбөр, Венчер Роверийн салбар хариуцсан товчооны гишүүд
11 сарын 30 гэхэд 4 аймаг, дүүргийн 150 хүүхдийг тус санал асуулгад хамруулж тайланг бэлтгэнэ.	Хөтөлбөр, Венчер Роверийн салбар хариуцсан товчооны гишүүд
2008 оны 12 сарын 30 гэхэд ҮЗХ-аар Венчер, Роверийн хөтөлбөрийн эхний хэсгийг батлуулахад бэлэн болгоно.	Хөтөлбөр, Венчер Роверийн салбар хариуцсан товчооны гишүүд
2009 оны 8 сарын 15-наас эхлэн судалгааны дүнд тулгуурласан венчир, роверийн хөтөлбөрийн 2-р хэсгийг боловсруулж товчооны хурлаар туршилт хийхээр батлуулна.	Хөтөлбөр, Венчер Роверийн салбар хариуцсан товчооны гишүүд
2009 оны 12 сарын 15 гэхэд судалгаанд тулгуурласан венчер, роверийн хөтөлбөрийг ҮЗХ-аар батлуулахад бэлэн болгоно.	Хөтөлбөр, Венчер Роверийн салбар хариуцсан товчооны гишүүд
2010 оны 1 сарын 15 гэхэд судалгаанд тулгуурласан венчер, роверийн хөтөлбөрийг ҮЗХ-аар батлуулна.	Хөтөлбөр, Венчер Роверийн салбар хариуцсан товчооны гишүүд
<b>Зорилт 2: 2009 оны 2 сараас хүүхэд, залуучуудын шинэчилсэн хөтөлбөрүүдийг Үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Гишүүнчлэл нэмэгдэж дараагийн насны ангилалд шилжих хүүхэд, залуучуудын хөгжил, Скаутын хөдөлгөөний нэр хүнд өснө.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 2 сарын 28 гэхэд шинэ хөтөлбөрийг хэвлэж вэб сайтад байрлуулна.	Хөтөлбөрийн дарга
2009 оны 4 сард удирдагчдад зориулсан гарын авлага, тэмдэгт, эмблем гаргана	Хөтөлбөрийн дарга
2009 оны 4 сард аймаг, дүүргүүдийн зөвлөлд шинээр гарсан хөтөлбөрийг гарын авлага эмблемийн хамт хүргүүлнэ.	Хөтөлбөрийн дарга
2009 оны 4 сард ядаж нэг удаа венчер болон роверийн бүлгийг удирдагч нарт зориулсан ерөнхий мэдээллийн сургалт, БУНБАШҮС-ийг зохион байгуулахаар сургалтын даргатай тохирно.	Хөтөлбөрийн дарга
2009 оны 9 сард залуучуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шинэчилсэн хүүхэд залуучуудын хөтөлбөрийг танилцуулах танилцуулгын сургалтын агуулгыг бэлтгэх	Хөтөлбөрийн дарга
2009 оны 10 сард бүх шатанд хүүхэд залуучуудын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтыг зохион байгуулах.	Хөтөлбөрийн дарга

2009 оны 11, 12 сард үндэсний хэмжээнд хөтөлбөрийг танилцуулах 15 сургалтыг зохион байгуулна	Хөтөлбөрийн дарга
2010 оны 4 сард шинээр батлагдсан венчер, роверийн хөтөлбөрийг шаардагддаг удирдагчийг гарын авлага, эмблемийн хамт хэвлэн АДСЗ-д хэрэгжүүлэхээр тараана	Хөтөлбөрийн дарга
2010 оны 11 сард венчер, роверийн бүлгийг удирдагч нарт зориулсан ЕМ болон БУНБАШҮС-ийг зохион байгуулахаар сургалтын даргатай хамтран зохион байгуулна.	Хөтөлбөрийн дарга
2010 оны 12 сард шинэчилэн боловсруулсан хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх хяналтыг зохион байгуулах арга хэрэгслийг зохион байгуулна.	Хөтөлбөрийн дарга
<b>Зорилт 3: 2011 оны 1 сар гэхэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад үнэлэлт өгнө.</b>	<b>Хүрэх үр дүн: Хүүхэд залуучуудын хөтөлбөрийн давуу болон сул талыг тогтооно. Саад бэрхшээлийг тогтооно.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2010 оны 8 сард хүүхэд залуучууд, эцэг эхчүүд, бүлгийн удирдагч нарт зориулан хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх судалгааны асуумж боловсруулна	Хөтөлбөрийн дарга
2010 оны 10 сард судалгааны асуумжийг үндэсний хэмжээнд явуулна.	Хөтөлбөрийн дарга
2010 оны 12 сард хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын судалгааны дүнг нэгтгэн, ҮЗ-ийн хуралд танилцуулахад бэлэн болгоно.	Хөтөлбөрийн дарга
<b>Зорилт 4: 2009 оны 10 сараас эхлэн үндэсний, орон нутгийн болон бүлгэмийн шийдвэр гаргах түвшний бүрэлдэхүүний 20% нь залуучууд байна.</b>	<b>Хүрэх үр дүн: Гаргаж байгаа шийдвэрт залуучуудын санал тусгагдсан байна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2008 оны 12 сарын 25 гэхэд үндэсний, орон нутгийн болон бүлгэмийн шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог баталгаажуулах баримт бичгийг боловсруулан ҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгоно.	Хөтөлбөрийн дарга
2009 оны 1 сарын 20 гэхэд ҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.	Гүйцэтгэх захирал
2009 оны 4 сард баримт бичигт тулгуурлан Залуучууд шийдвэр гаргах түвшинд хэрхэн оролцох журмыг боловсруулж ҮЗ-өөр батлуулна	Хөтөлбөрийн дарга
2009 оны 5 сард журмыг үндэсний хэмжээнд явуулна.	ҮТШ дарга
Жил бүрийн ҮЗ-ийн хурлаар үндэсний, орон нутгийн болон бүлгэмийн шийдвэр гаргах түвшинд залуучууд 20% эзэлж байгаа эсэхэд хяналт тавина.	МСХ-ны ерөнхийлөгч

### **Стратегийн хандлага: Насанд хүрэгчдийн нөөц**

**Насанд хүрэгчдийн нөөцийн цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлж, бүх шатанд хангалттай тооны, чадварлаг удирдагчидтай болно.**

<b>Зорилт 1: 2011 оны 12 сар гэхэд бүх аймаг, дүүрэгт анхан шатны нэгжтэй идэвхтэй ажиллаж байгаа 500 удирдагчтай болно.</b>	Хүрэх үр дүн: 2011 онд 1 сард насанд хүрэгчийн нөөцийн бодлого хэрэгжсэн байна. Идэвхтэй, чадвартай насанд хүрэгчдийн тоо нэмэгдэж, скаутын үйл ажиллагаа чанаржна.
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
Гишүүнчлэлийг өсгөх багтай хамтран шаардлагатай сургалтуудын тоог гаргана	Сургалтын дарга
2009 оны 4 сард шаардлагатай ерөнхий мэдээллийн болон БУНБАШҮСургалтыг зохион байгуулна	Сургалтын дарга
<b>Зорилт 2: 2009 оны 4 сар гэхэд насанд хүрэгчдийн нөөцийн бодлогыг батлуулан 2009 оны 6 сараас хэрэгжүүлж эхэлнэ.</b>	Хүрэх үр дүн: Хүүхэд, залуучуудын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлнэ. Зэрэглэлийн тэмдэгтэй скаутуудын тоо нэмэгдэнэ. Хүүхэд, залуучууд скаутын үйл ажиллагаанд тогтвортой оролцоно.
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 1 сарын 10 Үндэсний Зөвлөлийн хуралд боловсруулсан насанд хүрэгчдийн бодлогын хувилбараа санал болгон оруулна.	Ерөнхийлөгч
2009-7 сард Насанд хүрэгчдийн нөөцийн бодлогыг АДСЗ-д хүргүүлнэ	Ерөнхийлөгч
2009 оны 12 сар гэхэд насанд хүрэгчдийн нөөцийн бодлогын хэрэгжилтийг үнэлэх бүсчилсэн сургалтыг зохион байгуулна.	Ерөнхийлөгч
<b>Зорилт 3: 2011 оны 12 сар гэхэд аймаг бүр сургалтын багийн 1 ээс доошгүй гишүүнтэй болсон байна</b>	Хүрэх үр дүн: Бүсчилсэн сургалтуудыг зохион байгуулсан байна.
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 4 сар гэхэд 2, 3, 4 модон тэмдэгтийн сургалтанд суух боломжтой хүмүүсийн нэрсийг гаргах	Сургалтын дарга
2009 оны 11 сараас эхлэн 2 модон тэмдэгтийн сургалтыг жилд 1 удаа, 3 модон тэмдэгтийн сургалтыг 2 жилд 1 удаа, 4 модон тэмдэгтийн сургалтыг 3 жилд 1 удаа зохион байгуулна.	Сургалтын дарга
2009 оны 11 сараас Монголын нөхцөлд тохируулан бусад орны жишигт үндэслэн сургалтын багийн гишүүдийг томилох болон тавигдах шаардлагыг боловсруулж шинэчлэнэ	Сургалтын дарга

### **Стратегийн хандлага: Санхүүгийн бие даасан байдалтай болох**

*Санхүүгийн хяналтын тогтолцоог хэрэгжүүлж, бусад байгууллагуудтай /ТББ, Төрийн байгууллага, бизнесийн байгууллагууд гэх мэт/ хамтран ажиллах, дотоод нөөцөд тулгуурлан санхүүгийн эх үүсвэртэй болно.*

<b>Зорилт 1: 2011 оны 10 сар гэхэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа 4 аймаг болон Улаанбаатар хотод Скаутын үйл ажиллагааны төвийг бий болгоно.</b>	<b>Хүрэх үр дүн: Бие даасан сургалтын сайжирсан үйл ажиллагааны төвтэй болно. Сургалтын зардлыг багасгана. Түрээсийн орлогыг нэмэгдүүлнэ.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 6 сар гэхэд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа аймгууд дээр үндэслэн скаутын төв барих аймгийг сонгоно.	Гүйцэтгэх захирал
2009 оны 6 сард тухайн төвийг барих төсөл (төсөв, барилгын архитектур, тохижилт, бодлого, ажиллах журам, үүрэг хариуцлага..) -ийг боловсруулна.	Гүйцэтгэх захирал
2010 оны 1-р сараас Скаутын төв барих талаар хамтран ажиллах олон улсын, бизнесийн гэх мэт байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллах	Гүйцэтгэх захирал
2010 оны 3 сараас Скаутын төв барихаар сонгогдсон 4 аймагтай хэрхэн ашиглаж, ажиллуулах гэрээ байгуулна.	Гүйцэтгэх захирал
2011 оны 1-р сар гэхэд Скаутын төвийг барих төслийг хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэх захирал
<b>Зорилт 2: Жил бүр 10 сая төгрөгөөс доошгүй олох кампанит ажил 2-үүс доошгүйг зохион байгуулна. 2009 он оны 1 сараас эхлэн тусгай төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Жилийн төсөвт төлөвлөгдөөгүй тусгай хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009, 2010, 2011 оны 3 сард ямар кампанит ажил явуулах талаар Удирдах Зөвлөлөөр хэлэлцэх.	Ерөнхийлөгч
2009, 2010, 2011 оны 3 сард сар Удирдах зөвлөлөөс батлагдсан арга хэмжээний удирдамж боловсруулах	Ерөнхийлөгч
2009, 2010, 2011 оны 5 сард арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх	Гүйцэтгэх захирал
2009, 2010, 2011 оны 6 сард арга хэмжээнүүдийг дүгнэх (мөнгөн дүн, гарсан үр дүн...)	Удирдах зөвлөл
2009, 2010, 2011 оны 7 сард Удирдах Зөвлөл хуримтлуулсан фондыг ямар төсөл, хөтөлбөрт зарцуулахыг шийдвэрлэнэ	Удирдах зөвлөл
Санхүүжилт авсан төсөл, хөтөлбөрүүдийг тогтмол дүгнэж, шаардлагатай тайланг авна	Гүйцэтгэх захирал
<b>Зорилт 3: Скаут дэлгүүр, гишүүдийн татвар, үйл ажиллагаа, түрээсийн орлогоос байгууллагын жилийн төсвийн 30%-ийг санхүүжүүлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Скаутыг хөгжүүлэх хөрөнгөтэй болно. Хангамжийн үйл ажиллагаа сайжирна. Гишүүнчлэл нэмэгдэнэ.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2010 оны 1 сар гэхэд орлого бүрдүүлэх арга замаа тодорхойлж холбогдох хүмүүстэй хамтран ажиллана. Үүнд: Скаут дэлгүүр, гишүүдийн татвар, Төвлөрсөн арга хэмжээ, түрээсийн орлого	Гүйцэтгэх захирал

2009 оны 2 сар гэхэд скаут дэлгүүр, гишүүдийн татвар, үйл ажиллагаа, түрээсийн орлогоос хэрхэн орлого бүрдүүлэх бизнес төлөвлөгөөг тус тусад боловсруулж, хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэх захирал
2009 оны 6-р сараас эхлэн тавьсан үр дүндээ хүрч байгаад улирал тутамд үнэлэлт өгч, шаардлагатай шийдвэрүүдийг гаргана.	Гүйцэтгэх захирал
<b>Зорилт 4: 2009 оны 9 сараас санхүүгийн хяналтын тогтолцоог боловсронгуй болгож бүх шатанд хэрэгжүүлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Зарцуулалт сайжирна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2010 оны 1 сар гэхэд одоогийн санхүүгийн хяналтын тогтолцоонд үнэлгээ хийж боловсронгуй болгоно.	Хяналтын хорооны дарга
2010 оны 1 сард ҮЗХ-аар батлуулна.	Хяналтын хорооны дарга
2010 оны 4 сараас шинэчлэн гарсан санхүүгийн хяналтын журмыг хэвлэн бүх аймаг дүүрэгт хэрэгжүүлэхээр тараана.	Хяналтын хорооны дарга
2010 оны 12-р сараас АДСЗөвлөлүүдээс санхүүгийн тайланг шинэчлэгдсэн журмын дагуу авна	Хяналтын хорооны дарга
<b>Зорилт 5: 2011 оны 10 сар гэхэд 6 га газар бүхий зуслан, цугларалтын төвтэй болно.</b>	<b>Хүрэх үр дүн: 1000 хүн оролцсон скаутын Үндэсний үйл ажиллагааг явуулна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 12 сар гэхэд скаутын зуслан цугларалтын төв барих газрыг сонгоно.	Гүйцэтгэх захирал
2010 оны 3 сард тухайн төвийг барих төсөл (төсөв, барилгын архитектур, бизнес төлөвлөгөө)-ийг боловсруулна.	Гүйцэтгэх захирал
2010 оны 1-р сараас скаутын зуслан цугларалтын төвийг барих талаар хамтран ажиллах олон улсын, бизнесийн гэх мэт байгууллагуудтай гэрээ байгуулж ажиллах	Гүйцэтгэх захирал
Скаутын зуслан цугларалтын төвийн менежментийн багийг томилно. Уг баг нь төвийн бүх менежментийг хийх ба бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	Ерөнхийлөгч
2011 оны 1-р сар гэхэд скаутын зуслан цугларалтын төвийг барих төслийг хэрэгжүүлнэ.	Гүйцэтгэх захирал
2012 оны 12-р сараас эхлэн жил бүр төвийн менежмент ба санхүүгийн зарцуулалтанд үнэлгээ хийнэ.	Ерөнхийлөгч

<b>Стратегийн хандлага: Менежмент</b>	
<i>Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг сайжруулан бүх шатанд гишүүдийн хэрэгцээг хангах дүрэм, журмыг хэрэгжүүлнэ.</i>	
<b>Зорилт 1: Бүх түвшинд байгууллагын менежментийг сайжруулахын тулд 2010 оны 10 сард одоо байгаа бүтэц зохион байгуулалт, дүрэмд үнэлэлт өгч хэрэгжүүлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Байгууллагын бүтэц зохион байгуулалтыг сайжруулан хэрэгжүүлснээр бүх түвшинд үр дүнтэй менежмент бий болсон байна.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 6 сард менежментийг сайжруулахын тулд бүтэц, зохион байгуулалт, дүрмэнд үнэлэлт өгөх багийг томилно.	Ерөнхийлөгч
2009 оны 9-р сард бүтэц, зохион байгуулалт, дүрмэнд үнэлэлт өгөх баг нь дүрмээ нягтлан хянаж зөвлөмж гаргаж Үндэсний Товчоонд танилцуулна	Багийн ахлагч
2009 оны 12-р сард бүтэц, зохион байгуулалт, дүрмэнд үнэлэлт өгөх баг нь Үндэсний Товчооноос гарсан саналын дагуу зөвлөмжөө шинэчлэж ҮЗХ-аар батлуулахаар эцэслэн бэлтгэнэ	Багийн ахлагч
2009 оны 1-р сард Үндэсний Зөвлөлөөр батлуулах	Ерөнхийлөгч
2009 оны 3-р сард гэхэд Үндэсний Зөвлөлөөр батлагдсан баримт бичгийг шинэчилэн АДСЗ-д хэрэгжүүлэхээр тараана.	Гүйцэтгэх захирал
Жил бүрийн 12-р сард шинэчилсэн байгууллагын бүтэц, дүрэм, журманд үнэлгээн хийнэ.	Ерөнхийлөгч
<b>Зорилт 2: 2011 оны 6 сар гэхэд Эрсдлийн менежментийн бодлоготой болсон байна.</b>	<b>Хүрэх үр дүн: Бүх шатанд эрсдлийн менежментийн бодлого хүртээмжтэй болно. Скаутууд эрсдлийг буруулсан үйл ажиллагаанд оролцох боломжтой.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 4 сард Эрсдлийн менежментийн бодлогын эх загварыг боловсруулах ажлын хэсгийг томилж байгуулна.	Ерөнхийлөгч
2009 оны 10 сар – бусад үндэсний скаутын байгууллагуудын эрсдлийн менежментийн материал мэдээллийг танилцаж судална.	Ажлын хэсгийн ахлагч
2010 оны 1 сард баг бодлогын эх загварыг товчоогоор хэлэлцүүлэн батлуулна.	Ерөнхийлөгч
2010 оны 10 сард батлуулсны дараа бодлогыг эцэслэж, бүх АДСЗ-үүдэд хэрэгжүүлэхээр түгээнэ	Гүйцэтгэх захирал
<b>Зорилт 3: 2011 оны 10 сар гэхэд бүх аймаг, дүүргүүд байгууллагын дүрмийн дагуу үйл ажиллагаа нь явагдаж байгаад дүгнэлт хийнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Монгол дахь скаутуудын үнэн нүүр царай харагдана. Гишүүнчлэл нэмэгдэнэ. Байгууллагын менежмент дээшлэнэ.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2010 оны 5 сард АДСЗөвлөлийн гишүүдийг хамарсан үйл ажиллагаа болон санхүүгийн талаарх менежментийн сургалтыг зохион байгуулна.	Гүйцэтгэх захирал
2010 оны 1 сараас эхлэн Ерөнхийлөгч, Товчоо, ҮТШ-ийн ажилтнууд жил бүр 4 аймгийн СЗ-д очиж үйл ажиллагаатай танилцана.	Гүйцэтгэх захирал
АДСЗ-ийг улирал тутамд тайлагнахад дэмжлэг үзүүлнэ.	Гүйцэтгэх захирал
ҮТШ нь АДСЗ-ыг өөрсдийн онцлогт тохируулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Гүйцэтгэх захирал

## Стратегийн хандлага: Харилцаа холбоо

*Байгууллагын дотоод харилцааг /үндэсний, орон нутгийн, анхан шатны/ сайжруулан мэдээлэл, холбооны хэрэгслэлийг өргөнөөр ашиглан байнгын эргэх холбоотой ажиллана.*

<b>Зорилт 1: 2010 оны 1 сар гэхэд нийгэм дэх МСХ-ны талаарх эерэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор маркетингийн стратегийг боловсруулан хэрэгжүүлнэ.</b>	<b>Хүрэх үр дүн:</b> Маркетингийн материалууд болох вэб сайт, танилцуулга, видео, хэвлэлийн материалууд, баримт бичгүүд хүртээмжтэй болно. Байгууллагын талаарх гадаад, дотоод олон нийтийн хандлага дээшлэнэ. Олон нийтийн дэмжлэг өснө.
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 2 сард Маркетингийн төлөвлөгөөг боловсруулан Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн батлана	Удирдах зөвлөлийн маркетинг хариуцсан гишүүн
2009 оны 3 сараас эхлэн маркетингийн үйл ажиллагаа эхэлнэ.	Гүйцэтгэх Захирал
2009 оны 6 сард Вэб сайт бүрэн хэмжээгээр ажиллана.	Вэб сайт хариуцсан сайн дурын ажилтан
2009 оны 6 сард байгууллагын танилцуулгыг товхимол, VCD, DVD, CD, хэлбэрээр нийтэд болон гишүүддээ зориулан боловсруулж олшруулан ашиглахад бэлэн болгоно. "Скаут ньюс"-ийг 2 сар тутам бэлтгэн гаргаж интернэт болон шуудангаар тараана.	Олон нийттэй харилцах хариуцсан дарга
2009 оны 9 сараас эхлэн "Боловсрол" телевизтэй хамтран олон нийт, гишүүддээ зориулсан 30 минутын нэвтрүүлэг бэлтгэн сар бүр цацаж байна.	Гүйцэтгэх Захирал
2009 оны 9 сард Харилцаа холбоо тогтоох, интернет ашиглах талаар сургалтын гар авлагыг боловсруулан гаргаж бүх түвшний удирдагч нарт интернэтээр болон шуудангаар тараана.	Гүйцэтгэх Захирал
2009 оноос эхлэн жил бүрийн 6-р сарын 1, 9-р сарын 2 дахь 10 хоног байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан нэг өдрийн арга хэмжээг зохион байгуулдаг болно.	Олон нийттэй харилцах хариуцсан дарга
<b>Зорилт 2: 2010 оны 10 сар гэхэд бүх аймаг, дүүргүүдийн Скаутын Зөвлөлтэй интернэтээр харьцдаг, өөрийн компьютер техник хэрэгсэлтэй болсон байна.</b>	<b>Хүрэх үр дүн:</b> Бүх мэдээллийг бүх нэгжүүд цаг алдалгүй хүлээн авдаг болно. Оролцооны үйл ажиллагаа нэмэгдэнэ
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 7 сараас Аймаг, дүүргийн скаутын Зөвлөлүүдийг компьютер, техник хэрэгслэлээр хангах шалгуурыг боловсруулж, судалгаа хийнэ.	Гүйцэтгэх Захирал
2009 оны 7-р сард төсөл боловсруулан гадна, дотны байгууллагуудад хандана.	Гүйцэтгэх Захирал
2010 оны 11-р сард шаардлагатай компьютер, техник хэрэгслэлийг хүлээн авч, бүртгэнэ.	Гүйцэтгэх Захирал
2010 оны 4-р улиралд тогтвортой үйл ажиллагаатай Аймаг, дүүргийн Скаутын Зөвлөлүүдийн 50%-ийг, 2011 оны 1-р улиралд үлдсэн Зөвлөлүүдийг компьютер, техник хэрэгслэлээр хангана.	Гүйцэтгэх Захирал
2011 оны 4-р сараас эхлэн бүх түвшний удирдлагуудтай сард нэгээс доошгүй удаа харьцаж мэдээлэл өгөх, хариу мэдээ авах ажлыг зохион байгуулж тогтмолжуулна.	Гүйцэтгэх Захирал

## Стратегийн хандлага: Хамтын ажиллагаа

Байгууллагын зорилгод хүрэхийн тулд солилцооны хөтөлбөр, хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэн төр, захиргаа, төрийн бус, олон улсын, гадаадын, үндэсний скаутын байгууллагууд, бизнесийн салбарынхантай хамтын ажиллагаагаа хөгжүүлнэ.

<b>Зорилт 1: 2009 оны 12 сар гэхэд Гадаадын хоёр ҮСБ-тай урт хугацааны турш солилцооны хөтөлбөрөөр дамжуулан түншлэлийг бий болгоно.</b>	<b>Хүрэх үр дүн: Хүүхэд, залуучууд бусад улс орнуудын түүх, соёл, хөтөлбөрийн талаар мэдлэг олох боломжтой болно. Олон улсын аяллын туршлагатай болно. Энхтайван найрамдал, итгэлцлийг хөгжүүлнэ.</b>
<b>Үйл ажиллагааны үе шат</b>	<b>Хэн хэрэгжүүлэх</b>
2009 оны 7-р сар гэхэд МСХ хэрэгцээнд тулгуурласан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх төсөл боловсруулна.	Гадаад харилцааны дарга
2009 оны 12 сар гэхэд ямар улсын ҮСБ-тай хамтран ажиллахаа шийдвэрлэнэ.	Гадаад харилцааны дарга
2010 оны 3 сард МСХ-ноос солилцооны хөтөлбөрт оролцох оролцогчдыг сонгох	Гадаад харилцааны дарга
2010 оны 12 сард солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ	Гадаад харилцааны дарга
Жил бүрийн 2 сард хөтөлбөрийн үр дүнг дүгнэж, тайланг бэлтгэнэ. Тайланг цаашдын хамтын ажиллагааны төсөлд ашиглах ба бусад байгууллагуудад туршлага болгоно.	Гадаад харилцааны дарга
<b>Зорилт 2: 2011 оны 1 сар гэхэд байгаль орчин, эрүүл мэнд, чадавхи бэхжүүлэх, нөөц нэмэгдүүлэх чиглэлээр 20-иос доошгүй байгууллагатай харилцан хамтын ажиллагаатай болсон байна.</b>	<b>Хүрэх үр дүн: Гадаад хамтын ажиллагааг хөгжүүлж бэхжүүлнэ. Олон улсын түвшинд байгууллагын нэр хүнд өснө.</b>
<b>Үйл ажиллагааны үе шат</b>	<b>Хэн хэрэгжүүлэх</b>
2009 оны 7-р сар гэхэд МСХ хэрэгцээнд тулгуурласан хэрэгжүүлэх төсөл боловсруулна.	Ерөнхийлөгч
2009 оны 12 сар гэхэд хамтран ажиллах байгууллагуудыг олно.	Ерөнхийлөгч
2010 оны 3 сард хамтран ажиллах байгууллагуудыг сонгоно.	Ерөнхийлөгч
2010 оны 12 сард солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлнэ	Ерөнхийлөгч
<b>Зорилт 3: 2011 оны 10 сар гэхэд өөрийн орондоо АНДБ-ийн арга хэмжээг зохион байгуулна.</b>	<b>Хүрэх үр дүн: Алсын хараанд хүрэх нөөц бололцоо нэмэгдэнэ. Ижил төстэй байгууллагуудын талаарх ойлголт нэмэгдэнэ. Бусад хүүхэд, залуучуудын байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа сайжирна.</b>
<b>Үйл ажиллагааны үе шат</b>	<b>Хэн хэрэгжүүлэх</b>
2009 оны 6 сар гэхэд АНДБ-ийн үйл ажиллагаа зохион байгуулах зөвшилцөлд хүрнэ.	Ерөнхийлөгч
2009 оны 12-р сар гэхэд өөрийн орондоо зохион байгуулах төвлөрсөн арга хэмжээний төслийн саналыг бэлтгэнэ	Ерөнхийлөгч

2010 оны 5 төвлөрсөн арга хэмжээний төлөвлөгөөг гаргана.	Ерөнхийлөгч
2010 оны төвлөрсөн арга хэмжээг зохион байгуулах хөрөнгө босгох	Ерөнхийлөгч
2010 оны төвлөрсөн арга хэмжээг бэлтгэлийг хийнэ	Ерөнхийлөгч
<b>Зорилт 4: 2009 оны 12 сар гэхэд Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Хүүхдийн хөгжил"-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2 чиг үүргийг гүйцэтгэнэ.</b>	<b>Хүрэх үр дүн: Төр, засгийн дэмжлэгийг авна. Нийгэмд гүйцэтгэх үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.</b>
Үйл ажиллагааны үе шат	Хэн хэрэгжүүлэх
2009 оны 6 сард ЗГ, хүүхдийн оролцооны байгууллагуудын явуулж байгаа үйл ажиллагааны хөтөлбөрийг судалж хамтран ажиллах боломжтой ажлуудыг тодорхойлно.	Гүйцэтгэх Захирал/АДСЗөвлөлийн дарга
2010 оны 1 сар гэхэд боломжтой гэж тодорхойлсон ажлуудын гэрээг байгуулна.	Гүйцэтгэх Захирал/АДСЗөвлөлийн дарга
2010 оны 10 сараас эхлэн төслийг хэрэгжүүлж эхлэнэ.	Гүйцэтгэх Захирал/АДСЗөвлөлийн дарга
Төслийг хэрэгжүүлж дууссаны дараа төслийг тайланг гаргана.	Гүйцэтгэх Захирал/АДСЗөвлөлийн дарга